



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20.18 оны 04 сарын 09-ны өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

**Мэдээллийн үйл ажиллагааны
журам батлах тухай**

Говь ХК-ийн сайн засаглалыг бэхжүүлэх зорилгоор Мэдээллийн үйл ажиллагааны журмыг батлах тухай асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 76.1.13 дахь заалтыг үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн Мэдээллийн үйл ажиллагааны журмыг Хавсралт-1 ёсоор баталсугай.

Хоёр. Уг журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг компанийн ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ, Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан-д үүрэг болгосугай.

ТУЗ-ийн ДАРГА

ТУЗ-ийн ГИШҮҮД



Д.ГЭРЭЛМАА

Ц.БААТАРСАЙХАН

М.БАЯР

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Ж.ОЮУНЧИМЭГ

З.ШАГДАРСҮРЭН

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2018 оны 07 сарын 09 ний өдрийн хурлын
13 протоколын 1 дүгээр хавсралт



ГОВЬ ХК-ИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Мэдээллийн үйл ажиллагааны журам (цаашид “Журам” гэх) нь Говь ХК (цаашид “Компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд Компанийн талаарх үнэн зөв мэдээллийг тогтмол хүргэх, Компани нь хууль, дүрэм журамд заасан болон бусад чухал ач холбогдол бүхий мэдээллийг нээлттэй болгох, мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Журмыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Компанийн дүрэм болон зохицуулах байгууллагаас гаргасан бусад дүрэм журмын хүрээнд Компанийн ТУЗ-өөс баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.
- 1.3. Компани нь аливаа мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд байдлаар олон нийт, холбогдох эрх бүхий байгууллагад мэдээлэх үүрэгтэй.

Хоёр. МЭДЭЭЛЭЛ, ТҮҮНИЙ АНГИЛАЛ ЗОРИУЛАЛТ

- 2.1. Компаниас боловсруулан гаргаж буй мэдээлэлд Компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, санхүүгийн байдлын талаарх мэдээлэл болон хувьцаа эзэмшигч, олон нийтийн мэдвэл зохих бусад мэдээллүүд багтана.
- 2.2. Компаниас боловсруулан гаргаж буй мэдээллийг түүний зориулалт, нууцлалын шаардлага зэргийг харгалзан дараах үндсэн ангилалд хуваана. Үүнд:
 - 2.2.1. Олон нийтэд нээлттэй, тогтмол хүргэх мэдээлэл
 - 2.2.2. Нууцын зэрэглэлтэй мэдээлэл
 - 2.2.3. Бусад мэдээлэл
- 2.3. Олон нийтэд нээлттэй, тогтмол хүргэх мэдээлэлд Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-д заасан олон нийтэд тогтмол мэдээлэхийг үүрэг болгосон мэдээллүүд багтана. Үүнд:
 - 2.3.1. Хугацаат тайлан
 - 2.3.1.1. Компанийн хугацаат тайлан нь хагас жилийн болон жилийн үйл ажиллагааны тайлан гэсэн хэлбэртэй байна.



2.3.1.2. Компанийн жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайланд Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-н 2.3 болон 2.4-д заасан Компанийн бизнесийн үйл ажиллагаа, удирдлага, санхүүгийн байдал, хувьцаа эзэмшигчид, ногдол ашигтай холбоотой мэдээллүүдийг зайлшгүй тусгах бөгөөд хувьцаа эзэмшигч болон олон нийтэд хүргэх шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг нэмэлтээр тусгаж болно.

2.3.2. Тухай бүр нийтэд мэдээлэх мэдээлэл

2.3.2.1. Компанийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигч болон олон нийтэд Компанийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, эдийн засгийн үзүүлэлт, өмч хөрөнгийн болон удирдлага зохион байгуулалтын бүтэцтэй холбоотой мэдээллийг тухай бүр хүргэх үүрэгтэй.

2.3.2.2. Компаниас тухай бүр нийтэд хүргэх мэдээлэлд дараах мэдээлэл багтана. Үүнд:

2.3.2.2.1. Компанийн хөрөнгө, өр төлбөр, хувьцаат капитал болон үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх гэрээ хэлцэл байгуулах;

2.3.2.2.2. Борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувьд нөлөөлөх бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай байгуулсан гэрээ хэлцлийг цуцлах, дуусгавар болох;

2.3.2.2.3. Хөндлөнгийн аудиторын байгууллагатай байгуулсан гэрээ, түүний нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдээлэл;

2.3.2.2.4. Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн талаарх мэдээлэл;

2.3.2.2.5. Компанийн үл хөдлөх хөрөнгийн үнийн дүнгийн 10 ба түүнээс дээш хувьтай тэнцэх хөрөнгийг худалдах, барьцаалах болон бусад хэлбэрээр бусдад шилжүүлэх, битүүмжлэх, тусгаарлах;

2.3.2.2.6. Төлбөрийн чадваргүй болох;

2.3.2.2.7. Толгой, охин болон хараат компани өр төлбөрөө төлөх санхүүгийн чадваргүй болох;

2.3.2.2.8. Компанийн өрийг хувьцаагаар солих шийдвэр гаргах;

2.3.2.2.9. Үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлдээ зогссон;

2.3.2.2.10. Бизнесийн үйл ажиллагааны зарим хэсгийг охин, хараат компанид болон бусад этгээдэд шилжүүлэх, эсхүл хязгаарлах болсон;

529
"ЗЬЦА"
ТӨЛ
УЛ
3
ТТН
529

- 2.3.2.2.11. Үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлэх, хувьцааны ханшид нөлөөлөхүйц шинэ бүтээгдэхүүн зах зээлд танилцуулах;
- 2.3.2.2.12. Үндсэн болон шинэ бүтээгдэхүүнд зориулан тусгай зөвшөөрөл, патент, үйл ажиллагаа явуулах эрх, барааны тэмдэг эзэмших болон цуцлагдах;
- 2.3.2.2.13. Компанийн оноосон нэр, үндсэн захиргаа болон оршин байх хаяг байршил өөрчлөгдсөн;
- 2.3.2.2.14. Салбар, төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах болсон талаарх мэдээлэл;
- 2.3.2.2.15. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагад орсон өөрчлөлт;
- 2.3.2.2.16. Нийт ажиллагсдын 15 болон түүнээс дээш хувьд өөрчлөлт орох буюу чөлөөлөгдөх, шилжих, шинээр ажилд орох;
- 2.3.2.2.17. Бусад компанийн хувьцааны хяналтын багц болон түүнээс дээш хувийг худалдах, худалдан авах болсон;
- 2.3.2.2.18. Борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувийг эзэлдэг үйл ажиллагаатай холбогдох аливаа тусгай зөвшөөрөл /лиценз/ эзэмших болсон эсхүл түүнийг хүчингүй болгосон, барьцаалсан, аливаа хэлбэрээр бусдад шилжүүлсэн;
- 2.3.2.2.19. Шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох;
- 2.3.2.2.20. Хувьцааны опцион болон хувьцаа эзэмшигч компанийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрх бүхий нэмэлт хувьцаа гаргах шийдвэр;
- 2.3.2.2.21. Компанийг өөрчлөн байгуулах шийдвэр;
- 2.3.2.2.22. Компанийн хувьцааг хуваах, нэгтгэх шийдвэр;
- 2.3.2.2.23. Компанийг татан буулгах шийдвэр;
- 2.3.2.2.24. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр, хурлын зар болон түүний шийдвэр бусад холбогдох бичиг баримт;
- 2.3.2.2.25. ТУЗ-өөс гаргасан үнэт цаасны ханшид нөлөөлөх аливаа шийдвэр;
- 2.3.2.2.26. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл болон тэдгээрийн бусад компанид эзэмшиж байгаа хувьцааны өөрчлөлт;

2.3.2.2.27. Нийт гаргасан хувьцааны хяналтын багц эзэмшигчид болон эрх бүхий албан тушаалтнуудын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон;

2.3.2.2.28. Хувьцаа эзэмшигч болон олон нийтэд хүргэх шаардлагатай гэж Компанийн ТУЗ үзсэн бусад мэдээлэл

- 2.4. **Нууцын зэрэглэлтэй мэдээлэлд** Компанийн Нууцын тухай журамд заасан байгууллагын болон хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалагдсан мэдээллүүд багтана.
- 2.5. **Бусад мэдээлэлд** Компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүд буюу Компанид нэвтрүүлж буй шинэ бараа үйлчилгээний тухай, компанид болсон онцлох үйл явдлын тухай, маркетинг сурталчилгааны шинж чанартай зэрэг мэдээллүүд багтана.

Гурав. МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРУУЛАХ, ТҮГЭЭХ

- 3.1. Олон нийтэд нээлттэй, тогтмол хүргэх мэдээллийг ТУЗ болон Компанийн тухайн асуудлаар харьяалсан чиг үүрэг бүхий албан тушаалтан, газар, хэлтэс, алба, нэгжүүдийн хамтын ажиллагааны үндсэн дээр боловсруулан бэлтгэнэ.
- 3.2. Олон нийтэд нээлттэй, тогтмол хүргэх мэдээллийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга тухай бүр Хөрөнгийн бирж болон Компанийн цахим хуудсанд байршуулахаас гадна шаардлагатай тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагад бичгээр хүргүүлэх, холбоо харилцааны хэрэгслүүд, олон нийтийн мэдээллийн сувгуудыг ашиглан олон нийтэд хүргэнэ.
- 3.3. Хөрөнгийн бирж нь Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргад цахим хуудсанд мэдээлэл оруулах эрх /нууц дугаар бүхий эрх/ өгөх бөгөөд үүгээр дамжин мэдээллийг тухай бүр оруулж ажиллана.
- 3.4. Журмын 2.3.1-д заасан хугацаат тайлан буюу хагас жилийн үйл ажиллагааны тайланг жил бүрийн 08 сарын 01-ний өдрийн дотор, жилийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 04 сарын 01-ний өдрийн дотор тус тус Журмын 3.2-д заасны дагуу олон нийтэд мэдээлнэ.
- 3.5. Журмын 2.3.2-д заасан тухай бүр нийтэд мэдээлэх мэдээллийг тухайн үйл явдал, өөрчлөлт болсноос хойш ажлын 1 өдөрт багтаан Журмын 3.2-д заасны дагуу олон нийтэд мэдээлнэ.
- 3.6. Журмын 2.4-д заасан нууцын зэрэглэлтэй мэдээллийг шүүх, цагдаа, татварын байгууллага зэрэг төрийн эрх бүхий байгууллагын шаардлагаас бусад тохиолдолд мэдээлэхгүй.

525
"ЭМН"
ЛӨ
ДА
ЮЛ
2076
525

- 4.2. Дотоод мэдээлэл эзэмшигч, түүний холбогдох этгээд бүртгэлтэй үнэт цаас, түүнд суурилсан санхүүгийн хэрэгслийн арилжаанд дотоод мэдээлэл ашиглан оролцсон бол Журмын 4.1-д заасныг зөрчсөнд тооцно.
- 4.3. Компани нь дотоод мэдээлэл ашиглан арилжаа хийхийг хориглох бөгөөд үүнийг зөрчвөл Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэж арга хэмжээ тооцно.
- 4.4. Компани нь төөрөгдүүлсэн, хуурамч, бүрэн бус мэдээллийг нийтэд мэдээлэхийг хориглоно.
- 4.5. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Журмын 3.3-д заасан эрхийг компанийн ТУЗ-ийн зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах, ашиглуулах, хувийн зорилгоор ашиглахыг хориглоно.

Тав. БУСАД

- 5.1. Мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг Компанийн Гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан эрхлэн явуулах бөгөөд түүний ажиллагаанд ТУЗ хяналт тавьж ажиллана.
- 5.2. Гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь мэдээллийн ил тод байдлыг хангах явцад Компанийн нууц, дотоод мэдээллийг хууль бусаар, Компанийн ашиг сонирхлын эсрэг ашиглах явдлаас урьдчилан сэргийлж, хяналт тавих үүрэгтэй.
- 5.3. Аливаа мэдээллийн үнэн зөвийг уг мэдээг боловсруулсан болон хянасан албан тушаалтан хариуцна.
- 5.4. Энэхүү журам нь ТУЗ-ийн хурлаар баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 5.5. Журамд нэмэлт өөрчлөлт оруулах эрхийг ТУЗ эдлэх бөгөөд тухайн нэмэлт өөрчлөлтийг оруулан баталснаар энэхүү журмын нэгэн адил даган мөрдөгдөнө.
- 5.6. Журмыг зөрчсөн этгээдэд Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Компанийн дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 5.7. Журамд тусгагдаагүй аливаа асуудлыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн дүрэм, зохицуулах байгууллага, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гаргасан дүрэм, журамд зааснаар шийдвэрлэнэ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ